**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 05 өдөр    Дугаар А/36    Нарийнтээл сум

Орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/609 дүгээр захирамжийг тустус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн сумын салбар зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга. Г.Батсүх (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга. Б.Түмэндэмбэрэл (ЕБС-ийн захирал)
Гишүүдэд: С.Баасандулам (Хууль,эрх зүй хариуцсан мэргэжилтэн)
Б.Цэрэндолгор (Баянтээг багийн сургуулийн захирал)
Д.Ундармаа (Эрүүл мэндийн төвийн эмчлэгч эмч)
Г.Ганчимэг (СӨББ-ын багш)
Ч.Цэцэгжаргал. /Соёлын төвийн номын санч/
Ц.Шинэ-Эрдэнэ. /Монгол хэлний багш/
Т.Батдулам (Насан туршийн боловсролын нэгжийн багш)
Л.Загармаа (Иргэний төлөөл)

2.Монгол бичгийн хэрэглээ соёлыг нэмэгдүүлж, албан байгууллага, аж ахуй нэгжийн гадна хаяг, албан өрөө тасалгааны хаяг, нэрийг шинэчлэн хос бичгээр бичих ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллахыг орон тооны бус салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Түмэндэмбэрэл)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/205 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА    Б.СУГАР

G22411071

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 05 өдөр          Дугаар А/37          Нарийнтээл сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1, 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Залуучуудын фитнесс төвд тоног төхөөрөмж худалдан авах" үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Сайнбилэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүд: О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)

Ц.Сувд-Эрдэнэ (Нягтлан бодогч)

Д.Данаасүрэн (Иргэний төлөөл)

Нарийн бичгийн дарга: Ч.Оюунзул (Архив, бичиг хэргийн ажилтан)

2."Залуучуудын фитнесс төвд тоног төхөөрөмж худалдан авах" ажлыг гүйцэтгэх тендерийн техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах, нээх, хаах, тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Сайнбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА          Б.СУГАР

G22411073

D.My:Doc.A4Zahiramj /ZD/

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 05 өдөр Дугаар А/38 Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын төвд хөгжим техник хэрэгсэлийн хөрөнгө оруулалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Сайнбилэг (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)

Гишүүд: Ш.Ууганбаяр (ЕБС-ийн дуу хөгжмийн багш)
Т.Эрдэнэсүрэн (СӨББ-ын дуу хөгжмийн багш)
Ц.Цэвээнсүрэн (Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ж.Цэрэннадмид (Орон нутаг судлах танхимын ажилтан)

2.Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмыг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Сайнбилэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 05 өдөр | Дугаар А/39 | Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Ерөнхий боловсролын сургууль болон спорт заалыг камержуулах" ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Мөнхдэлгэр (Нийгмийн ажилтан)

Гишүүд: М.Гандолгор (ЕБС-ийн бага ангийн менежер)
Д.Энхбаатар (Нийгмийн багш)
Ж.Чинзориг (ЕБС-ийн сантехникч)

Нарийн бичгийн дарга: Б.Сосорбурам (Бага ангийн багш)

2.Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмыг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Мөнхдэлгэр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 05 өдөр Дугаар А/40 Нарийнтээл сум

Зөвлөл байгуулах тухай

Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн "Журам батлах тухай" А/238 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Батсүх (Засаг даргын орлогч)
Гишүүд: М.Ганжаргал (Соёлын төвийн эрхлэгч)
Л.Батнаран (Экологийн асуудал хариуцсан байцаагч)
О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)
Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)
О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)
Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)

2.Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах журмын хэрэгжилтэд хяналт тавьж хэрэгжилтийг хангаж ажиллахыг (Г.Батсүх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411079

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 05 өдөр Дугаар А/41 Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд цас их орж зудын нөхцөл байдал үүсч малчдын нөхцөл хүндэрсэн тул малын тэжээлийн дэмжлэг болгон 10,008,000 (арван сая найман мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг эрсдлийн сангаас гаргахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411081

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 11 өдөр | Дугаар А/42 | Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2024 оны төсөв батлах тухай" 2023 оны 12 дугаар 18-ны өдрийн 15/07 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол цэргийн баярт зориулсан шагайн харвааны тэмцээний зардалд 490.000 (дөрвөн зуун ерэн мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын Тамгын газрын биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622411081

D.My:Doc.A4Zahiramj /ZD/

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр Дугаар А/43 Нарийнтээл сум

Туслалцаа үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн Д.Алтанцэцэг, Т.Жаргалантуул, Д.Дашдзэвэг, Л.Цэдэвдорж нарын ар гэрт гачигдал гарсан тул оршуулгын зардалд зориулан 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөгийг зарцуулж хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411083

D.My:Doc.A4Zahirami./ZD/

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 18 өдөр | Дугаар А/44 | Нарийнтээл сум

Орон тооны бус зөвлөлийг татан буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Тушаал хүчингүй болгох тухай А/20 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Шийдвэр хүргүүлэх тухай 04/460 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийгмийн даатгалын багц хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх "Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох орон тооны бус зөвлөл"-ийг татан буулгасугай.

2.Орон тооны бус зөвлөл татан буугдсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/192 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411086

D.My:Doc.A4Zahiramj /ZD/

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 20 өдөр | Дугаар А/45 | Нарийнтээл сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хавсралтанд дурьдагдсан 1 иргэн, 1 аж ахуй нэгж байгууллагын нийт 0.3366 га /3366.0 м²/ газар эзэмших эрхийг сунгасугай.

2.Газар эзэмшигчдэд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Н.Мягмаржав)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411089

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 21 өдөр | Дугаар А/46 | Нарийнтээл сум

Хорио цээрийн дэглэмийг цуцалж хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн "Жагсаалт, журам батлах тухай" 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар хавсралтын 6.1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн "Шар хад", "Навчтын ам", "Эргүү", "Бор хошуу", "Хараат ягааны ихэр" гэдэг газарт өвөлжиж байгаа малчин Р.Нэргүй, Р.Жаргал, Р.Мандах, А.Чимэдцэрэн, Д.Төрмөнх нарын хонинд 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс хойш хонины цэцэг өвчний өвчлөл нэмэгдээгүй тул хорио цээрийн дэглэмийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөр цуцалж, 2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр хүртэл 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Тухайн бүс нутагт байгаа малд эмнэл зүйн үзлэгийг тогтмол хийх, өвчний голомт бүхий газарт халдваргүйжүүлэлт хийж ажиллахыг "Бумбат суварга" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Д.Цэцгээ)-д үүрэг болгосугай.

3.Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг иргэдэд сурталчилж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (П.Төмөртогоо), 2 дугаар багийн Засаг дарга (Б.Базарсад) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-д даалгасугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/29 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411031

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 26 өдөр Дугаар А/47 Нарийнтээл сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ард иргэдийн аюулгүй амгалан тайван байдлыг хангах зорилгоор сумын цагдаагийн хэсэгт интернетийн зардлын дэмжлэгийг сар болгон үзүүлсүгэй.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 26 өдөр Дугаар А/48 Нарийнтээл сум

Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн анги байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн
Даргаар: Г.Батсүх (Сумын Засаг даргын орлогч)
Орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтнаар: Б.Ичинноров (Засаг даргын Тамгын газрын дарга)
Аюулгүй байдал хариуцсан ажилтнаар:С.Баасандулам (Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)
Холбоо хариуцсан ажилтнаар: Б.Мөнгөнтуяа (Холбооны ажилтан)
Хангалт хариуцсан ажилтнаар: Г.Наранхүү (Төсвийн ерөнхий нягтлан бодогч) нарыг тус тус томилсугай.

2.Сумын гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Гамшгаас хамгаалах сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлж, бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг чиглэлийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн а/38 дугээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411095

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 26 өдөр Дугаар А/49 Нарийнтээл сум

Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7, 32 дугаар зүйлийн 32.1.2, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Сайн дурын хэсгийн багаж, зэвсэглэмжийн нөөцийг бүрдүүлж сайн дурын хэсгийг арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 07 дугээр сарын 18-ны өдрийн А/128 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411097

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 28 өдөр Дугаар А/50 Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2024 оны төсөв батлах тухай" 2023 оны 12 дугаар 18-ны өдрийн 15/07 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдааны зардалд 930.000 (есөн зуун гучин мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын Тамгын газрын биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622411099

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 28 өдөр Дугаар А/51 Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдааны зардалд 688,000 (зургаан зуун наян найман мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622411101

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 28 өдөр | Дугаар А/52 | Нарийнтээл сум

Бүх нийтийн цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж албан байгууллагуудад өөрийн өмчлөл, эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн талбайн 50-100 метр газарт орчны хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосугай.

2.Өөрийн өмчлөл, эзэмшилийн хашааны орчны хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2024 оны 03 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллахыг иргэдэд үүрэг болгосугай.

3.Иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагын бүх нийтийн цэвэрлэгээнд хяналт тавьж зохион байгуулж ажиллахыг Багийн Засаг дарга (Ц.Мөнх-Эрдэнэ), Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Г.Наранбаатар), Экологийн асуудал хариуцсан цагдаа (Л.Батнаран) нарт даалгасугай.

4.Бүх нийтийг хамарсан их цэвэрлэгээний зардлыг тооцож шийдвэрлэхийг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22411103

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/53 Нарийнтээл сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянтээг бага сургуулийн багш нарыг Улаанбаатар хотод сургалтанд хамрагдахад 262.000 (хоёр зуун жаран хоёр мянган) төгрөгний дэмжлэг үзүүлж тооцоог хавсралтаар зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G224111

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр Дугаар А154 Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.8.1, 9.8.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд хонь, ямааны цэцэг өвчин голомтлон гарсантай холбогдуулан хэрэгжүүлсэн вакцинжуулалтын арга хэмжээний зардалд 1.715,700 (нэг сая долоон зуун арван таван мянга долоон зуун) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар батлсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

C224111?7

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
## НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
## ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/55 Нарийнтээл сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах,
орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн "Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулах" тухай 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэижээг зохион байгуулах тухай" А/193 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нийт бэлчээр, уст цэгийг бохирдлоос хамгаалж зүй бусаар хорогдсон мал, амьтдын сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч. Г.Батсүх (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)
Г.Наранбаатар (Байгаль орчны мэргэжилтэн)
П.Төмөртогоо (Тархвар зүйч)
Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Л.Батнаран (Экологийн асуудал хариуцсан байцаагч)
О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)
Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)
О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)
Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)
Д.Цэцэгээ ("Бумбат суварга" БГБХ нөхөрлөл

2.Малын сэг зэм устгах ажлыг чанартай зохион байгуулж иргэд малчдыг мэдээллээр хангаж хүн, хүч техник хэрэгслийг дайчлан ажиллуулж хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Г.Батсүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/56 Нарийнтээл сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний, төлөвлөгөө, удирдамж батлуулах тухай” А/26 дугаар тушаал, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хуваарь батлах тухай” А/14 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А193 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд мал сүргийг халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж “Бумбат суварга”, “Бумбат-Ур” хувийн мал эмнэлгийн эмч нарт үүрэг болгосугай.

2.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, товлосон хугацаанд мал сүргийг бэлэн байлгах, зар мэдээллийг цаг тухайд нь хүргэж, бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах тарилгыг цаг хугацаанд нь татан авч, хувийн мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүдэд хүргэх, мэргэжил, арга зүйгээр хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, баримт бичгийн бүрдүүлэлт, мэдээ тайланд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Бямбадолгор)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

№ 022411111